

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-24

**1.Боловсролыг дэмжих жилийн хүрээнд авч
хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх 3-24
Боловсролын сайдын мэдээллийг сонсох**

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны
11 дүгээр сарын 24-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга С.Зулпхар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 49 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Хосбаяр.

Нэг.Боловсролыг дэмжих жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Цахим боловсрол, статистик мэдээллийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч Э.Батсэлэм, Сургуулийн өмнөх боловсрол, боловсролын удирдлагын байгууллагын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч Д.Гансүмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Ц.Долгормаа, Б.Энхмаа нар байлцав.

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Д.Рэгдэл, Ц.Мөнхтуяа, Б.Хэрлэн, Ц.Баатархүү, С.Зулпхар нарын тавьсан асуултад Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал,

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Дэд хорооны дарга С.Зулпхар тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар танилцуулав.

С.Зулпхар: “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 3
Бүгд: 8
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд Боловсролыг дэмжих жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалын хийсэн мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 9 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ДЭД ХОРООНЫ ДАРГА

С.ЗУЛПХАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр,

Даваа гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”

танхим

14 цаг 49 минут.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДЭД
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Зулпхар: Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна. Дэд хорооны ирц 55,6 хувьтай бүрдсэн тул Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны 2025 оны 11 сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж гишүүдээс санал байна уу? Санал байхгүй байна. 2025 оны 8 сарын 25-ны өдөр, 26-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүд салбарын холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийн талаар, 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд Боловсролын салбарын 2026 оны төсвийн төслийн танилцуулга сэдвээр Боловсролын сайдын мэдээллийг сонссон.

Уг мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг үндэслэн Боловсролыг дэмжих жилийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгохоор Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан гишүүдэд тараасан байгаа.

Дэд хорооны хуралдаанд оролцож байгаа одоо би та бүхэнд албан тушаалтнуудыг танилцуулъя. Хуралдаанд Боловсролын сайд Наранбаяр, цаг үеийн асуудал яаралтай нөхцөл байдалтай холбоотойгоор гарсан учраас Ерөнхий сайд дээр сайд уулзалттай байна. Энд Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал хүрэлцэн ирсэн байна. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн, Дээд болон мэргэжлийн боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Нарангэрэл, Цахим боловсрол, статистик мэдээллийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Цогзолмаа, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир хараахан хүрэлцэн ирээгүй байна. Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн захирал Оюунаа, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч Батсэлэм, Сургуулийн өмнөх боловсрол, боловсролын удирдлагын байгууллагын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч Гансүмбэрэл гэсэн ийм бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулаад тогтоолын төслийн танилцуулгыг та бүхэнд хийе. Тогтоолын төсөл бол Улсын Их Хурлын Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүдийн санаачилгаар жишээ нь энэ бэлэн

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

болгочихсон ийм тогтоолын төсөл. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад бид Боловсролын яам, холбогдох газруудаас зохих түвшний саналуудыг авсан байгаа. Тийм учраас хуралдааны дэгийн дагуу бид энэ танилцуулгыг манай дэд хороо өөрөө танилцуулаад, тэгээд энэ тогтоолтой холбоотой асуудлаар асуулт гишүүд маань асууна. Гишүүдийн асуултад санаачлагч, тэрнээс гадна Боловсрол, шинжлэх ухааны яам, холбогдох албан тушаалтнууд хариулах ёстой юм байгаа юм. Тэгэхлээр би та бүхэнд энэ тогтоолын төсөлтэй холбогдуулсан товчхон танилцуулгыг хийе.

Учир юу гэхлээр зэрэг энэ тогтоолын төсөл маань боловсролын салбарын бүхий л асуудлыг аль болох жишээ нь хамарсан байхаар боловсруулагдсан учраас 11 хуудас ийм тогтоолын төслийн танилцуулга байгаа юм. Энийг тэгээд гишүүд маань бас уншиж танилцана. Явцдаа асуулт асуух, санал хэлэх үедээ энэтэй холбоотой нэмэлт оруулах, магадгүй өөрчлөлт оруулах, засвар хийх, магадгүй өөрчлөн найруулах ийм саналууд хэлээд явах байх гэж бодож байна.

Би тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл. 2025 оны 8 сарын 26-ны өдөр Боловсролын сайд Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүдэд салбарын холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилт, 2025 оны 9 сарын 23-ны өдөр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд боловсролын салбарын 2026 оны төсвийн төслийн танилцуулга сэдвээр Боловсролын сайд П.Наранбаяр тус тус мэдээлэл хийсэн. Мөн 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласан сайдын мэдээллийг үндэслэн боловсролын салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүдийн саналыг авч, Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг бэлтгэлээ.

Тогтоолын төсөл боловсролын бүх түвшинд нэн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн түвшинд хамааруулан авч үзсэн. Харин тогтоолын төсөлд тусгасан арга хэмжээ нь өрсөлдөх чадвартай боловсролын тогтолцоог бэхжүүлэх, боловсролын чанар, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг эрчимжүүлэх, багшийн мэргэжлийн хөгжлийн чадамж, хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах, боловсролын дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт, зохицуулалтын үр дүнтэй бүтэц бий болгоход чиглэсэн болно.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг багшийн ажилласан жилээс үл хамаарч, тэдний чадамжид суурилсан ажил үүргээ гүйцэтгэхэд нь шууд хэрэглээ болох агуулгад чиглүүлэн ажлын байранд болон орон нутаг, үндэсний түвшинд үр дүнтэй зохион байгуулах, мөн анхны жилдээ ажиллаж байгаа багшийг багшлах ажилд дагалдуулан сургах зайлшгүй шаардлагатай байна.

2. Шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжилд англи хэлийг дэлхийн нийтийн мэдээлэл солилцож харилцахад хамгийн түгээмэл хэрэглэдэг хэл гэдгийг хүлээн зөвшөөрөөд байна. Дэлхий нийтийн хөгжлийг дагаад нийгмийн харилцаа, технологийн хэрэглээ, боловсрол, сургалт, хөдөлмөрийн салбарт заавал эзэмшсэн байх ур чадварын нэг нь англи хэл болоод байна. Өнөөдөр дэлхийн 100 гаруй улс орон гадаад хэлний сургалтыг бага ангиас эхлүүлдэг бөгөөд энэ нь олон улсын нийтлэг жишиг болсон байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт англи хэлний 2 мянган багшийг гадаад, дотоодод бэлтгэж, мэргэжлийг дээшлүүлэх

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

зорилтын хүрээнд 2025 онд багтаан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 300 хүртэлх багшийг англи хэлний чадамжийн түвшин ахиулах богино хугацааны сургалтад гадаад улсад хамруулна. Цаашид жил бүр 300-аас доошгүй англи хэлний багшийг гадаад улсад сургах, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн англи хэлний багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулж, боловсронгуй болгох, бага ангийн багш англи хэл заах чадамжтай төгсдөг болгоход чиглэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар анхан шатны мэргэжлийн ур чадвар болох төрөл бүрийн сургалтын төвүүд, жолооны болон хэлний сургалтыг багтаасан нийт 1246 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2025 онд 6053 чадамжийн нэгжээр хөтөлбөр хэрэгжүүлж, 61881 чадамжийн гэрчилгээ олгогдсон нь мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн байна. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын сайдын эрхлэх хүрээнд шилжүүлэх арга хэмжээ үе шаттай, шат дараатайгаар хэрэгжиж байгаа ба мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны бодлого, зохицуулалтыг оновчтой шийдвэрлэх шаардлага мөн адил тулгамдаж байна.

Төрийн өмчийн 1814 сургалтын байгууллагад 93475 албан хаагч ажиллаж байна. Үүнээс 58 мянга нь багш буюу нийт салбарын албан хаагчдын 62,2 хувийг эзэлнэ. Насны бүтцээр нь авч үзвэл багш нарын 41 хувь нь 35-аас доош насныхан бөгөөд нийт багшийн 60 хувь нь орон нутагт, 40 орчим хувь нь нийслэлд ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн сарын дундаж цалин үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, унаа, хоол, гүйцэтгэлийн үнэлгээ ороод татварын өмнөх байдлаар 2680989 төгрөг байгаа боловч шинээр ажилд орж байгаа залуу багшийн үндсэн цалин 1484000 мянган төгрөгөөс эхэлж байна. Багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, багшийн ур чадвар, ажлын ачаалалд нийцүүлэн цалин хөлсний бүтцийг бий болгоход зориулж 100 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлуулаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехникийн коллеж, Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар, 2026 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 26 хувиар тус тус нэмэгдүүлнэ. Дээрх заалттай холбоотойгоор 518,6 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар Боловсролын сайдын багцад нэмэлтээр баталсан. Иймд 2026 оны төсвийн тухай хуулиар нэмж батлагдсан 618,6 тэрбум төгрөг болон цалин хөлсний бүтцэд өөрчлөлт оруулах байдлаар үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар, 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 26 хувиар тус тус нэмэгдүүлж шийдвэрлэх шаардлага бий болж байгаа.

Бидний энэ танилцуулга маань 11 хуудас. Тэгээд сая би хэлсэн бид ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол, цаашлаад түр жишээ нь сургалт гэсэн энэ чиглэлээр бүгдээр нь тодорхой та бүхнээс авсан саналын дагуу тогтоолын төслийг, танилцуулгыг бэлэн болгосон байгаа. Тэгэхлээр энэнтэй холбоотой зүйлийг та бүхэн уншиж танилцах байх. Нөгөөтээгүүр асуулт асуугдах байх гэж бодож байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд маань асуулт асуух гишүүн байвал та бүхэн асуулт асуух бол кнопоо дарна уу. Асуулт асуух гишүүд Баатархүү гишүүнээр тасалбар болгоё. Наранбаяр сайд цаг үеийн асуудалтай холбоотойгоор

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Ерөнхий сайд дээр яаралтай уулзалттай байгаа юм байна. 15 цагаас бас Засаг дээр асуудал хэлэлцэж болзошгүй ийм нөхцөл байдал байгаа учраас Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан холбогдох газрын дарга нар хүрэлцэн ирсэн байгаа. Та бүхэн бас асуулт асуувал холбогдох албан хаагчид асуултад хариулаад явах нь. Дарааллын дагуу тэгвэл асуултаа асууя, Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд бид ирэх жилийг Боловсролыг дэмжих жил болгуулсан, болгосон байж байна. Энэ их ач холбогдолтой. Сая төсөв хэлэлцэхэд ер нь ингээд ярьж байгаа гишүүдийн тоог харахад бүгдээрээ л Боловсролыг дэмжих жил болгосон учраас тэр багш нарын цалинг нэмэх асуудлыг ч бүгдээрээ дэмжиж байна. Тэгээд нэмэлтээр бүсчилсэн хөгжлийн юугаар гишүүд нэмэлт төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж оруулж ирэхэд ерөөсөө л сургууль, цэцэрлэг дээр нэлээн төсөл, арга хэмжээнүүдийг тавьсан. Та бүхэн энэнтэй ингээд танилцсан байх.

Тэгэхээр бид энэ тогтоол гарч байгаа нь их цаг би олсон асуудал байна гэж бодож байна. Тэгээд энэ тогтоол дээр тусаж байгаа зүйлийг өнөөдөр бүгдээрээ бас би бол draft маягаараа байгаа гэж ойлгож байгаа тийм ээ. Энэ дээр нэмж чамбайруулж ингэж орох зүйлүүд гарч ирэх байх гэж бодож байна. Миний хувьд нөгөө талаас яг энэ хажууд хуралдаж байгаа Үндсэн хуулийн энэ танхимд бид 5 жилийн үндсэн чиглэлийн талаар ярьж байгаа. Тэгээд энэ дээр зарчмын зөрүүтэй нэлээн олон саналууд оруулсан. Зарим нь ороод, зарим нь ингээд хасагдаж байна.

Тэгэхдээ энэ бүгдээс ингээд харж байхад манай Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас оруулж ирж байгаа яг тэр сургалтынхаа чанарыг дээшлүүлэх талын тийм бодитой, тэгээд хэрэгжиж болох, бид яг тийм агуулга руугаа, мөн чанар луугаа орж ярих тийм зүйлүүд их ховор байгаад байна. Та бүхэн маань ийм мэргэжлийн хүмүүс байж байгаа юм. Ерөөсөө л нөгөө хэдэн сургуулиа барья, хэдэн цэцэрлэгээ барья, дотуур байраа барья гэдэг юман дээр, тэгээд цалингаа нэмье гэдэг ийм л асуудал яригдаад байна шүү дээ.

Тэгэхээр бид одоо сургуулиудынхаа тэр удирдлагын бүтэц, зохион байгуулалт, захирлуудыг бэлдэх, сургуулийн бие даасан байдлыг хангах, энэ асуудлаас эхлээд, тоног төхөөрөмж бүүр хиймэл оюун ухааныг ашиглая ч гэдэг зүйлүүд нэлээн яригддаг шүү дээ. Тэгээд энэ зүйлүүд энэ тэр чинь энэ юун дээр виртуал багш, сурагчийн туслах энэ тэр гээд зүйлийг ч бид ингээд зөндөө ярьсан зүйлүүд ингээд өмнө нь сонсоод ингээд ирсэн. Тэгээд энэ бүгд маань ерөөсөө тодорхой ингээд тусаж орж ирэхгүй байгаад байх юм.

Тийм учраас би бол мэдээллийг энэ мэргэжлийн хүмүүсээсээ яамныхнаасаа бас нэлээн сайн сонсож, хийх гэж байгаа үйл ажлууд төлөвлөөд байгаа. Жишээлбэл тэр бидний төсөвтэй холбогдуулж баахан ярьсан тэр hard гэдэг юм уу, дэд бүтэц юуны асуудлаас гадна, илүү яг сургалтын чанар сайжруулах талаар хийж байгаа тийм онцгой онцлогтой аргууд. Жишээ нь сая дэд дарга маань ярьж байна л даа, Зулпхар дарга англи хэлийг бид сайжруулж байгаа, сайжруулах талын арга хэмжээнүүд авна.../минут дуусав/

С.Зулпхар: Галбадрах гишүүний асуултад Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Х.Батжаргал: Батжаргал Боловсролын яам. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яах аргагүй боловсролын чанарын асуудлыг хөндөж ярихад боловсролын хүртээмж, орчны асуудал чухлаар тавьдаг. Тэр ч утгаараа гишүүний хийсэн судалгаа, бас яамд хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хүртээмж тал дээр нэлээн тодорхой ахицууд гарч, өөрчлөлтүүд төсөв дээр суугдаад бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа. Нөгөөтээгүүр чанарыг ахиулах хэмжээнд цаг үеийн шинжтэй, нөгөөтээгүүр урьдчилан төлөвлөгдөөд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаад явж байгаа гол ажил бол сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн ажил явж байгаа. Тэгээд энэ жилийн хувьд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг боловсруулан батлуулаад, хэрэгжилтийг хангаад явж байна.

Энэ хичээлийн жилдээ бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн ажлыг батлуулж, дараагийн хэрэгжилт рүү орох ёстой. Тэгэхээр үүнтэй холбоотой гишүүний хөндөж тавьж байгаа багшийн ачааллыг бууруулах, шинэ ялангуяа шинэ техник, технологи, хиймэл оюуны асуудлаар дэлхийн тэргүүлэгч компани болох Google компанитай хамтраад, багш нарыгаа эхний ээлжид ямар ч байсан хиймэл оюунаар сургах, хиймэл оюуныг багш нар бүрэн сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөгөө боловсруулахдаа ашигладаг байх тэр дэд бүтэц бэлэн байдлыг хангаад ингээд ажиллаж байгаа.

Нөгөөтээгүүр сургалтын чанарыг ахиулахын тулд багшийн хөгжлийг дэмжсэн, ажлын байран дээрээ хөгжих мэргэжлийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээнүүдийг улам эрчимжүүлж бэхжүүлэхээр тусгагдаж байгаа. Өөрөөр хэлбэл Багшийн хөгжлийн үндэсний төвийг дамжуулаад, Бүсчилсэн хөгжлийн бодлоготойгоо уялдуулаад бүс болгон дээр их сургуулийнхаа салбар сургуулиудаар дамжуулж, багшийн хөгжлийг дэмжсэн энэ үйл ажиллагааг явуулахаар бэлтгэл ажил буюу сургалтын төлөвлөгөө агуулгын хүрээнд бэлэн болгоод, холбогдох эрх зүйн орчин зохицуулалтыг нь хийгээд ажиллаж байгаа. Эхнээсээ энэ хичээлийн жилд багшийн хөгжлийг ажлын байран дээрээ дэмжсэн энэ сургалт үйл ажиллагааг аймгуудын Боловсролын газрыг чадавхжуулах замаар, нөгөөтээгүүр багш бэлтгэх үндсэн гол сургууль болох Монгол Улсын Боловсролын их сургуулийг түшиглэн байгуулагдаж байгаа Багш хөгжлийн төвөөр дамжуулж энэ ажлуудыг хийгдэнэ.

Бас нэг гол ажил бол багш нарын нийгмийн баталгааг хангах чиглэлээр Багш нарын 3 тулгуурт энэ хөгжлийн бодлогыг улам эрчимжүүлэх бас нэг боломж нь энэ саяхан батлагдсан Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан төсөв, 26 оны төсвийн жилд хэрэгжүүлэхэд нэлээн ахиц дэвшил гарахаар ийм заалтууд тусгагдсан байгаа гэж хэлэх байна.

С.Зулпхар: Галбадрах гишүүн дарга нэмэлт асуулт асууна тодруулж.

Ж.Галбадрах: Тийм, бид бүгд одоо англи хэл гээд сая дэд дарга Зулпхар даргын хэлсэнчлэн 3 дугаар ангиас үзээд эхэлсэн. Тэгээд Боловсролын яам 100 сургууль дээр өнгөрсөн жил хэрэгжүүлсэн гэж үзэж байгаа. Тэгээд энэ хэзээ болох вэ? Гэтэл өнөөдөр бид ерөөсөө багшаа бэлдэхгүйгээр шууд ингээд орчихоор нэг энэ алаг цоог яваад байдаг. 3 дугаар ангиас нь англи хэлээ үзэхээр эргээд нөгөө дунд анги дээрээ бас англи хэлнийхээ гүйцэд багшаа бэлдээгүй учраас яваад байгаа. Ийм маягаар бид бэлтгэл дутуу маш их ороод байгаа. Ер нь л би энэ багш бэлтгэх тал дээр, багш мэргэжлээр элсэж байгаа хүүхдүүдийн элсэлтийн ерөнхий

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

шалгалтын оноог нь өндөр оюутнуудыг элсэх талаар ямар бодлого явуулж байна вэ чанаржуулах? Тэгээд төгсөөд гарч байгаа оюутнууд дөнгөж 30 хэдхэн хувьтай, өнгөрсөн жил бүүр 15-хан хувьтайгаар багш болсон байна лээ шүү дээ 24 онд төгссөн хүүхдүүд. Тэгэхээр энэ тоон дээр та нар маань энэ талаар ямар арга хэмжээ авч байна вэ? Яг багшийн.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуусан энэ багшийн хомсдол, ялангуяа энэ англи хэлний хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлэх болсонтой холбогдуулаад энэ санаа зовж байгаа асуудал маш чухал асуудал. Тэгэхээр энэ бэлтгэл ажлаа, бэлэн байдлыг хангах хүрээнд туршилтын журмаар зохион байгуулаад тэр хүрээндээ энэ Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас 10 сая фунт стерлингийн туслалцаа, буцалтгүй тусламжийн хүрээнд бид англи хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд голлох бэлэн байдлыг хангах, багш нарын хөгжлийг дэмжсэн энэ ажлуудыг хангаж эхлүүлсэн байгаа. Хамгийн гол асуудал бол энэ багш бэлтгэх асуудал. Энэ бэлтгэл, туршилтын хугацаанд ч гэсэн тулгамдаж байгаа, сорилт дагуулж байгаа нэг гол чухал асуудал байгаа. Тэгэхээр Боловсролын зээлийн сангийн шугамаар хэрэгжиж байгаа хэрэгжилтийг хангах хүрээнд энэ гэрээний биелэлт дээр онцгой ач холбогдол өгч, гэрээний биелэлт дээр.../минут дуусав/

С.Зулпхар: Галбадрах гишүүн тодруулах уу?

Ж.Галбадрах: Тэгье, тэгье. Тэгэхээр энэ дээр бид багшийн дутагдлыг арилгана, нэмэгдүүлнэ гээд ингээд баахан тоо тавьчихсан. Би уг нь нэг ийм 4 чиглэлээр явъя гээд Батжаргал даргатай санал солилцоод л байсан. Би элсэлтийн өндөр оноотой төгсөгчдийг элсүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр байгаад байгаа багш мэргэжилтэй боловч багшаараа ажиллахгүй байгаа хүмүүсийг эргэж татах талаар, тэр зах зээлээс л бид татахгүй бол одоо сургуулиуд шинээр барья гээд бид 108 сургууль, 95 цэцэрлэг гээд ингээд явахаар улам л шинээр бариад, норм нормативыг нь хангая гэхээр улам л багш маань дутах гээд байна.

Тэгэхээр одоо би барьж аваад л, зөвхөн багш гээд л ярихад л өчнөөн олон асуудал ингээд яригдаад байна л даа. Тэгэхээр бүгдээрээ яг энэ тал дээр нь, илүү багш нарын карьер гэдэг юм уу, багш нарынхаа ажил дээр одоо гараад ажиллаж байгаа хүмүүс чинь нэг л багш болбол тэр чигээрээ насаараа тэр тухайн сургуульдаа ингээд байх юм шиг л ийм байгаа бол энэний карьер төлөвлөлт энэ тэр дээр ямар зүйлүүд бодож.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Тэгэхээр гишүүний хөндөж байгаа энэ асуудал дээр саяын бидний хэлэлцэж байгаа Боловсролыг дэмжих жилийн хүрээнд батлагдсан төсөв бас их түлхэц дэмжлэг үзүүлэхээр байгаа. Тухайлбал хамгийн гол бидэнд сорилтыг дагуулаад байсан асуудал бол ажлын байран дээрээ ажиллаж байгаа багш нараа бусад салбар мэргэжил рүү алдаад байсан ийм асуудал байсан. Тэгэхээр энэ төсвийн хэрэгжилтийн хүрээнд багшийн үндсэн суурь цалинг нэмэгдүүлэх 50 хувиар нэмэгдүүлэх, цаашлаад 27 оныг угтаж 3 сая 500 мянгад суурь цалинг хүргэх мөн түүнчлэн багшийн энэ цалингийн бүтэц дээр нэлээн дорвитой өөрчлөлтүүдийг хийх энэ хүрээнд ямар ч байсан эхний үе шатад ажиллаж байгаа багш нар, ялангуяа эхний 5 жил хүрээгүй ажиллаж байгаа залуу

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

багш нарынхаа энэ боломж нөөцийг бүрэн ашиглах ийм нэг хөшүүрэг. Нөгөөтээгүүр бусад салбар, ялангуяа хувийн хэвшил.../минут дуусав/

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл асуулт асууна, микрофоныг өгье.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр 26 оны улсын төсөв дээр ер нь хамгийн их амжилттай төсөв авсан салбар бол боловсролын салбар байгаа. Хөрөнгө оруулалт талдаа ч тэр, урсгал зардал талдаа ч тэр. Тийм учраас зөвхөн эцэг, эхчүүд төдийгүй Монголын ард түмэн 26 оноос эхлээд л энэ хөрөнгө оруулалтын өгөөж, төсвийн зарцуулалтын өгөөжийг гарцаагүй шаардаж эхэлнэ. Тэр тал дээр нэмэр болохуйц тогтоол гарах ёстой. Энэ тогтоолыг ерөнхийд нь ингээд харахлаар зэрэг их л ерөнхий их олон ажил биччихсэн байх юм. Их олон ажил.

Би юу асуух гэж байна вэ гэхээр энэ сургуулиудад, сургуулийн хичээлийн байр манай Галбадрах гишүүн байнга ярьдаг 200 орчим сургууль барьчихвал анги дүүргэлт хэвийн болох гэх мэт. Гэтэл энэ сүүлийн 10 гаруй жил, 15 жил санагдаж байна төрөлт байнга буурч байгаа. Жилдээ 87 мянга орчим төрөлттэй байсан бол одоо 58 мянга руу ороод явчхаж байгаа. Энэтэй холбогдуулаад энэ хүүхдийн өсөлт, сургуулийн сурагчдын тооны өсөлтөөр хийсэн ямар нэгэн дүн шинжилгээ байна уу? 7 жилийн дараа, 6 жилийн дараа энэ чинь 1 дүгээр ангид хэдэн хүүхэд орохоор байна вэ? Энэтэй холбогдуулаад энэ хичээлийн байр барих асуудлаараа та бүхэн маань ямар дүгнэлт хийж байгаа юм гэж нэг асуумаар байна?

2 дугаарт энэ хөгжлийн, багш хөгжлийн төвүүд байдаг юм байна, энэ үндэсний хэмжээний болоод бүсийн хэмжээний төвүүд байна. Тэгэхээр энэ хэчнээн төв Монголд ажиллаж байна, энд хэчнээн хүн ажилладаг юм, энэ төвүүд чинь яг юу хийдэг юм бэ? Энэ багш бэлддэг сургуулиуд байгаад байдаг, тэнд баахан төв гээд байгаад байдаг юм биш биз. Энэ дээрээ та нар судалж үзсэн судалгааны юм ер нь юу байна вэ?

3 дугаарт энэ манай дээд боловсрол болох, мэргэжлийн боловсролыг орхичихъё. Дээд боловсролын гол зорилго зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нийцүүлсэн мэргэжилтэн бэлтгэх гол асуудал энд байгаа юм. Тэгээд энэ тогтоолд орсныг харахаар зэрэг зарим мэргэжлийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд уялдуулан тогтоож, тогтоох бодлогоо боловсронгуй болгоно гээд бичээд байгаа. Гэтэл мөн чанар нь дээд боловсрол тэр чигтээ зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, шаардлагыг хангасан хүний нөөцийг бэлтгэх асуудал байгаа юм дээд боловсролд. Тэгэхгүйгээс болоод дээд боловсролын чанар муу байдаг нь үнэн, яг төгсөөд очсон хүн салбарын хэрэгцээг огт хангаж чаддаггүй. Энэ тал дээр бас нэг дорвитой ахиц дэвшилт гаргамаар байгаа юм. Зарим улсууд буруу тайлбарлаад байдаг шүү дээ, ингээд ямар ч байсан нэг дээд.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Боловсролын жилийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулаад ажлын хэсгүүд, Их Хурлын холбогдох Байнгын хорооноос ч оролцоод, салбарын яамнууд оролцоод тэгээд нэлээн бодитой судалгаан дээр үндэслээд холбогдох шийдвэрүүдийн төслүүдийг оруулсан байдаг. Ялангуяа энэ гол хүүхдийн тэгш хүртээмжтэй холбоотой асуудал дээр хүүхдийн тооны өсөлт гишүүний хөндөж тавьж байгаа энэ маш чухал

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

асуудал. Тэгэхээр 2026-аас 2028, цаашлаад 30 он хүртэл энэ сургуулийн хамрагдалтад шинээр 88 мянган хүүхдийн ийм хэрэгцээ шаардлага шинээр бий болохоор байгаа юм. Мэдээж хүүхдийн төрөлт, хүн амын өсөлт динамик өсөлт цаашдаа тогтворжиж байгаа хэдий ч гэсэн энэ эхний ээлжид бид энэ шинээр бий болж байгаа энэ хэрэгцээг бүрэн хангах тэр орчныг бэлдэх нь зайлшгүй хэрэгцээ гэдэг утгаараа энэ 108 сургууль, 95 цэцэрлэгийг барих нь хамгийн эхний тэр шинээр энэ сургууль хамрагдалтад орж ирж байгаа тэр орон зайг хангах энэ ажил байгаа юм гэж байгаа юм.

Цаашлаад бид энэ барилга байгууламж энэ дээр хангалттай гэж ханаад зогсох ёсгүй. Өөрөөр хэлбэл бид 2 ээлж, 3 ээлжийн эрсдэлийг бууруулж байгаа, 2 ээлжтэй энэ сургуулиуд цаашлаад олон улсын жишгээрээ нэг ээлжтэй болох ёстой. 1 ээлж үлдсэн цаг хугацаа, сургалтынхаа цаг хугацааг дугуйлан, сургалт, сонирхлын бусад чиглэлээрээ хөгжүүлэх энэ бүх боломжийг хангах ийм боломж цаашдаа дунд хугацаандаа болон урт хугацаандаа нээгдэх ёстой юм байгаа юм. Тэгэхээр бидний энэ төлөвлөж байгаа энэ хүртээмжийг нэмэгдүүлэх гэж байгаа энэ хөрөнгө оруулалт бол дөнгөж шинээр бий болж байгаа хэрэгцээгээ хангахад чиглэж байгаа. Дахиад цаашлаад бид дахиад нэг ээлж рүү шилжихэд томоохон арга хэмжээ авах болно гэдгийг бас хэлье.

Багш хөгжлийн төв энэ шинэ тутам шинэ Боловсролын багц хууль батлагдсантай холбогдуулж ажлын байран дээрээ багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр байгуулагдсан энэ бодлогын хэрэгжилт хангагдаад явж байгаа. Одоогоор бүсүүдийг бүсийн хэмжээнд зохион байгуулагдаж байна. Жишээлбэл баруун бүс дээр Ховд аймагт Ховд Их сургуулийг түшиглээд, Архангай аймагт Багшийн коллеж, Боловсролын их сургуулийг түшиглээд, Дорнод аймагт Монгол Улсын Их сургуулийн салбар сургуулийг түшиглээд, Боловсролын багш хөгжлийн үндэсний төв бол Боловсролын Их сургуулийн дэргэд байгуулагдаж ингэж үйл ажиллагаа явагдаж байгаа. Энэ нь өөрөө шинээр багш бэлтгэнэ гэхээс илүүтэйгээр ажлын байран дээр ажиллаж байгаа багш нарынхаа тасралтгүй мэргэжлийн хөгжлийг нь дэмжих чиглэлээр ажиллана.

Мэдээж Боловсролын их сургууль, үндсэн багш бэлтгэж байгаа их сургуулиудын боловсон хүчин, хүний нөөц, эрдэмтэн профессоруудын дэмжлэг туслалцаа энэ хөтөлбөрийн агуулга, сургалтын энэ бэлтгэл ажил дээр оролцоод, хангагдаад, ингээд хамтын зохион байгуулалтаар ороод явж байгаа. Эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг нь хангаад ингээд өнгөрсөн жилээс хэрэгжиж эхэлж байна.

Дээд боловсролын тухайд хамгийн гол асуудал бол яах аргагүй хөдөлмөрийн эрэлтэд нийцсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангахуйц хүний нөөцийг бэлдэх энэ гол зорилго оршиж байгаа. Түүний хажуугаар мэргэжлийн судалгаа, эрдэм шинжилгээний энэ ололт, инновацын түвшинд нь дэлгэрүүлэх, тэгээд судалгаа шинжилгээ хийгдсэн энэ ажлуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, судалгааны цаашлаад их сургууль болох энэ бэлтгэл ажлыг хангахад чиглэсэн гол бодлогууд бас үргэлжилж явагдахаар зорьж байгаа. Сургалтын, их сургуулиудын сургалтын хөтөлбөр, сурагчдын, оюутнуудын сургалтын хяналтын тоонд чиглэсэн эрэлттэй тэргүүлэх мэргэжлийг шинэчилсэн эдгээр ажлууд хийгддэгээрээ хийгдээд явахаар төлөвлөлтөд бол.../минут дуусав/

С.Зулпхар: Рэгдэл гишүүн, нэмж тодруулж асууя.

Д.Рэгдэл: Тэгэхээр ер нь яах вэ тэр сургуулийн байр барих асуудлыг бид ойлгоод байгаа. Гэхдээ ер нь нарийн тооцоо заавал хийх ёстой. Ер нь энэ сургуулийн насны хүүхдийн төрөлт 10 жилийн, 8 жилийн дараа энэ тэр гээд хийх нь гарцаагүй зөв юм байгаа юм.

2 дугаарт энэ багш хүрэлцээгүй гэдэг асуудал байнга л яригдаад байдаг. Энэ бараг л санал байх, асуулт биш байх. Ер нь их сургуулиуд ямар ч мэргэжлээр төгсгөсөн багш заах аргын хичээлийг нь оруулаад, сэтгэл зүйн хичээлийг нь оруулаад ингээд багш хийх бүрэн бэлтгэлтэй төгсгөчихдөг л дөө. Манайд тэр нь байхгүй болчихсон, бусад олон газар байгаа. Тэгэхээр энэ тал дээр та нар нэг бодлого боловсруулж ажиллавал, Монгол Улсын Их сургууль физикээр төгслөө гэхэд тэр хүн аль ч шатад физикийн хичээл заадаг, заах аргыг нь эзэмшихсэн, сэтгэл зүйг нь сайн.../минут дуусав/

С.Зулпхар: Рэгдэл гишүүнд нэмж бас хугацаа өгье.

Д.Рэгдэл: Хуулиудад энэ гадаад хэл 3 дугаар курсээс эхлээд англи хэл ордог л хуультай болж байна шүү дээ. Тэгэхээр энэ тогтоолын төслийг бол яам бодвол үзэж харсан байх. Англи хэл судлах гээд байгаа юм. Энэ хүүхдүүд хэл судлах ямар ч шаардлагагүй шүү дээ. Эд нар чинь хэл сурах ёстой юм байгаа юм, анхан шатны мэдлэгтэй болох, хэл судална гэдэг чинь хэл шинжилдэг улсууд ийм улсууд байдаг. Тэгээд энэ Их Хурлын Байнгын хорооны тогтоол дээр англи хэл судлах гээд орчихвол нөгөө хүүхдүүд чинь хэл шинжилгээний эрдэмтэн судлаач болох хандлага руу ороод явчих вий гэж ингэж нэг болгоомжлох юм байгаа.

Дараагийн нэг асуудал бол энэ багшийн асуудал. Энэ намраас эхлээд ер нь багшийн асуудал гайгүй болох болов уу гэж бодоод байгаа. Яагаад гэвэл сая цалин нэмэгдсэн сургаар манай зарим хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд шууд сургуульд багшильа гээд өргөдөл өгч байгаа сураг байгаа. Энэ цалинтай холбоотой.

С.Зулпхар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа асуулт асууна.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид жил гаруй л гишүүн болсноосоо эхлээд л ер нь энэ миний ярьдаг юм бол сэдэв ерөөсөө л багш нарын цалин хөлс, нийгмийн баталгаа. Тэгээд өнөөдөр багшийн хомсдолыг хөтөлбөрөөр, орчноор мэргэжил дээшлүүлснээр арилгана гэж бодоод байгаа юм уу, үгүй шүү дээ. Багшийн хомсдол чинь ерөөсөө л нийгмийн баталгаа байхгүй учраас л ийм хомсдолд орчихоод байгаа шүү дээ. Тэгээд сая төгрөгийн цалин аваад, би магистрт гадаадад суръя гэсэн багш байхгүй, үнэхээр байхгүй. Миний цалинг 3 сая 500 мянга болгоод өгөөч гэсэн багш хэдэн мянгаараа байна.

Тийм учраас одоо бид боловсролын салбарынхаа асуудлыг эрэмбэлмээр байна. Тэгээд л нэг тулга тойрсон юм ярьсаар байтал 1 жил, 2 жил өнгөрнө, ингээд л нэг мэдэхэд бидний энэ 4 жил өнгөрнө. Тийм учраас миний санаа зовж байгаа гол асуудал бол энэ Боловсролын ерөнхий хуульд би нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 42 гишүүний хамт өргөн барьж, санаачлаад ингээд өргөн барьчихсан байгаа. Тэгээд энэ намрын чуулган руу хэлэлцэгдэх байх гэж бас найдаж байна. Тэгээд ер нь энэ төгсөгчдийн 30 гаруй хувь нь л багшилж байна

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

гээд судалгаагаар байна гэж сая Галбадрах гишүүн хэлж байна. Тэгээд тэр 60 гаруй хувь нь хаачсан юм бэ гэхээр ерөөсөө л цалин хөлс, нийгмийн баталгаа шүү дээ. Цалин нь сая төгрөгийн цалин аваад тэр залуу багш түрээсэндээ бараг цалингаа өгөөд, цаана нь дахиад өртэй үлдэж байна гэж уйлаад ярьж байсан шүү дээ.

Бид жоохон хөрсөн дээрээ буусан юм ярихгүй, тэр л олон хөтөлбөр, төлөвлөгөө, гоё, гоё юм яриад, агаарын юм ярьдгаа одоо болимоор байна. Энэ боловсролын салбарынхаа асуудлыг ядаж эрэмбэлэе хэдүүлээ. Хамгийн чухал юм чинь ерөөсөө л нийгмийн баталгаа шүү дээ. Цалин нь бага болохоор эд нар Солонгос руу байрны урьдчилгаа хийх гээд явж байна. Цалин нь бага учраас уурхайд том тэрэг барих гээд явж байна. Тэгээд цалингүй ингэж амьдарч байснаас гээд наймаа хийж байна шүү дээ багш нар, лангуун дээр сууж байна шүү дээ. Тэгээд энэ багш нарыг бид хөтөлбөр төлөвлөгөө шинэчлээд, өөрчлөөд татна гэж тийм юм бол байхгүй. Бид хамгийн 1 дүгээрт цалинг нь нэмэх хэрэгтэй, мянган долларт хүргэх хэрэгтэй. Энэ өнөөдөр ярьж байгаа асуудал биш, 2017 оноос Монголын мянга мянган багш нар төр засагт шаардаж цалингаа нэмүүлэе гээд тэмцэж жагсаад ирсэн. Тэгээд өнөөдөр шийдсэн юм байхгүй.

Тэгээд нэг хэдэн худлаа тоо яриад л, хэдүүлээ хэдэн биеэ хуураад ийм тулга тойрсон юм ярьж суудгаа одоо болимоор байна. Би үнэхээр ичиж байна, багш нараас үнэхээр ичиж байна. Тэгээд ийм юм хийх дургүй гишүүд энд сууж байдаг юм уу. Үнэхээр боловсролын салбараа дэмжэе, боловсрол тэргүүлэх салбар, багшийн цалинг нэмэх нь зөв гэж бүгдээрээ ярьдаг. Бүгдээрээ энийг яриад сонгуульд санал авч гарсан шүү дээ. Тэгээд 28 онд бид багш нарынхаа өмнө юу хэлээд суух юм бэ?

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүнд цагийг нь нэмж өгье.

Ц.Мөнхтуяа: Ер нь энэ бид нарын энэ жил болгон ингээд тулга тойроод л хэрүүл хийдэг асуудлыг шийдэх гол гарц бол Боловсролын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт, одоо энэ хуульчлаад өгсөн нь л хамгийн зөв оновчтой болно. Бид олон улсад ч гэсэн үүрэг хүлээчихсэн шүү дээ, дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 7 хувийг, төсвийн зардлынхаа 20 хувийг боловсролдоо зарцуулна гээд Инчоны тунхаглал дээр Боловсролын сайд гарын үсэг зураад, Засгийн газар үүрэг хүлээчихсэн шүү дээ 15 онд. Тэгээд 10 жил өнгөрч байхад ямар ч өөрчлөлт байхгүй ийм ингээд бахь байдгаараа сууж байдаг. Тэгээд нөгөө гадаадаас авсан зээл, тусламжаа энэ төсөл төсөв дээрээ нэмчхээд нэг их тоо яриад, тэр Азийн хөгжлийн банкны 150 сая доллар чинь зөвхөн сургууль, цэцэрлэгийн барилгад л явах мөнгө шүү дээ. Энэ бол багшийн цалин хөлс, нийгмийн баталгаанд ямар ч хамааралгүй. Бид нарын хамгийн гол юм багшаа татах юм чинь ерөөсөө л цалин хөлс шүү дээ. Тэгээд одоо энийгээ л ярья. Ер нь энэ төсвийн.../минут дуусав/

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүний асуулт их тодорхой асуулт байна. Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Тогтоолын төсөл 26 оныг Боловсролын жил болгон зарласантай холбогдуулж хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд батлагдсан төсөвт багтааж төлөвлөсөн ёсоор цалин хөлсийг нэмэх төлөвлөгөө бол нарийвчлаад төсвийн задаргаа байдлаар боловсрогдоод явж байна. Үйлдвэрчний

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

эвлэлтэй байгуулсан хамтын хэлэлцээрт ч орсон байгаа. Тэгэхээр 1 сарын 1-нээс багш нарын үндсэн суурь цалинг 50 хувиар нэмэгдүүлэх, оны төгсгөлд 2 сая 800 мянган төгрөгт хүргэх, цаашлаад 3 сая 500 мянган төгрөгт үндсэн цалинг хүргэх энэ ажлыг авч хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлагдсан, төсөв батлагдсан энэний дагуу хэрэгжээд явна.

Мэдээж хуульчлах асуудал бид эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдалтай, макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад 3 жилийн төлөвлөлтийг төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарыг батлах тухай хуулиар зохицуулаад явдаг байгаа. Тэгэхээр тэр төсвийн хүрээний мэдэгдэл хязгаартай уялдуулаад бид энийг авч үзэх ёстой байх гэж бодож байна. Дээр нь шууд яг энэ хэмжээнд Инчоны тунхаглалд төсвийн зарлагын 20 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 6-аас 8 хувьд хүргэх энэ асуудлыг шууд салбарын яам дангаар оруулж ингэж хийх бол нэлээн сорилттой, учир дутагдалтай байгаа гэдгийг хэлье.

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Энэ одоо яг энэ Батжаргал даргын хэлж байгаа ч бас үнэн л дээ. Ганц яамны хийх ажил биш. Ер нь энэ Засгийн газрын гишүүд, Их Хурлын гишүүд, шийдвэр гаргах түвшний бид бүгдээрээ л энэ багш нарынхаа цалин хөлсийг нэмье гэж ярьдаг. Худлаа ярьдаг байхгүй юу. Үнэхээр нэмэх гээд байгаа юм уу гэхээр кноп дээрээ дардаггүй шүү дээ. Нөгөө хэдхэн салбарын төлөө зовдог хэдхэн хүн л хөөрхий кнопдоод л сууж байдаг, ихэнх нь дардаггүй. Тэгээд зам, барилга болохоор учиргүй их уурлаж минчийгээд л зам дээр тавиулна гээд кнопоо дараад байдаг. Би бол энэ 28 онд хэн нь дарж, хэн нь дараагүйг нь би шууд л зарлана. Ер нь тэгээд бүгдээрээ боловсролын салбар тэргүүлэх гэххээд яагаад энэ салбарт ажиллаж байгаа гол нөгөө ажиллах хүчин болсон багш нарынхаа нийгмийн асуудлыг ерөөсөө ярьдаггүй юм бэ? Тэгээд нэг шал хэрэгцээгүй юмнууд яриад л өдөр хоногийг өнгөрөөгөөд баймааргүй байна. Одоо би нэг юм асууя Батжаргал даргаа. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр шинэчилсэн гэж байна.../минут дуусав/

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүн нэмж цаг өгье.

Ц.Мөнхтуяа: 25 онд багтааж бага боловсролын хөтөлбөр шинэчилнэ гэнэ, одоо хийгдээд эхэлчихсэн үү, дуусчихсан уу ер нь? Одоо 25 он чинь дууслаа, энэ байхгүй. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ гээд ингээд намар 1 дүгээр ангийн хүүхдүүдээс авдаг шүү дээ, тэр байхгүй. 23 оноос хойших мэдээлэл нь байхгүй. 23-аас 24 он, 25-аас 26 он байна уу, тэр байхгүй. Ингээд ер нь нөгөө яг ингээд голдирлоороо явж байсан бүх ажлууд чинь нураад байна, унаад байна. Энэ юман дээрээ бас жоохон анхаарахгүй бол яамны ажил ерөнхийдөө нэлээн уначихсан байна гэдгийг багш нар аягүй их ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ боловсролын салбарын хамгийн чухал амин судас болсон энэ багш нарынхаа цалин хөлс, нийгмийн баталгааг ярихгүй бид тулга тойрсон мянган хөтөлбөр, мянган сайхан мөрөөдөл яриад хэрэг байхгүй. Зөвхөн зориг гаргаад одоо бид хиймээр байна. Үнэхээр 26 он Боловсролын жил гээд, эсвэл ганц.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж тодруулъя. Энэ гишүүдийн саяын нэмэлт олон саналууд гарч, баталж өгсөн төсвөөр ер нь дотоодын нийт бүтээгдэхүүний 5,2 хувьд, төсвийн зарлагын 16,4 хувьд хүрэх ийм ахиц энэ жилийн хувьд гарсан байгаа. Хөтөлбөрийн тухайд сая Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр хэрэгжээд одоо бол явж байгаа. 2025 он, 25-аас 26 оны хичээлийн жилдээ энэ бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн ажлыг хийж байгаа. Хамгийн гол нь энэ өөрөө шууд боловсруулах, батлуулах энэ явц өөрөө дардан биш, сорилттой байгаа. Өөрөөр хэлбэл зарим нэгэн иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан гомдлын дагуу шүүхийн шатад энэ явж байгаа процессыг тодорхой хэмжээгээр хугацаа саатах ийм тохиолдол гарч байгаа нь яах аргагүй үнэн. Тэгэхээр энэ шүүхийн шатны процесс шийдэгдсэнээр дараагийн.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга нэмж тайлбарлая.

Х.Батжаргал: Тэгэхээр бага боловсролын хөтөлбөр батлагдах яг энэ хүрээнд шүүхийн шатанд иргэдийн гаргасан гомдлыг хэлэлцэх ажил бол шүүхийн процесс явж байгаа. Энэ асуудал нэг талдаа гарч шийдэгдсэнээр дараагийн төлөвлөгөөний дагуу бид, ер нь боловсруулах ажил бэлэн болоод 80 гаруй хувьтай бэлэн болчихсон явж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр энэ хичээлийн жилдээ багтаад хэрвээ шүүхийн ямарваа нэгэн энэ асуудал саатлаас шалтгаалахгүй бол бид төлөвлөгөөний дагуу баталж, хэрэгжүүлэх боломж хангагдана.

С.Зулпхар: Батжаргал дарга баярлалаа. Би Мөнхтуяа гишүүний асуулттай холбогдуулаад бас нэг нэмэлт тайлбар хэлье. Тогтоолын төслийг бид хамтдаа санаачилж байгаа. Та бүхэн бас тогтоолын төсөл дээр саналуудаа өгсөн. Одоогийн байдлаар 4 бүлэг, 21 зүйл ийм жишээ нь тогтоолын төсөл байгаа юм. Нэмж санал оруулах нээлттэй. Байгаа жишээ нь зүйл болон бүлгүүд, зүйл болон заалтууд дээр бас өөрчлөлт оруулах нээлттэй гэж байгаа юм.

Тэгэхлээр зэрэг яах вэ таны хэлсэн нөгөө цалин хөлстэй холбоотой асуудлыг 2 дугаар бүлэг дээр оруулсан байгаа. Тухайлсан бүлэг болгоод сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллеж, насан туршийн суралцахуйн төвүүдийн багш, ажилтны цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, цалингийн бүтцийг оновчтой болгох бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх гэсэн нэг ийм томъёолол байж байгаа. Тэгэхлээр зэрэг ийм томъёолол орсон байгаа шүү. Энэ дээр хэрвээ санал байвал гишүүн саналаа хэлээд явна. Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Сая Батжаргал даргын тоон дээр би бас юу байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 16, дотоодын нийт бүтээгдэхүүний 5 гаруй хувь гэсэн тийм ээ, 5,3 хувь гэсэн тийм ээ, тэгээд төсвийн зардлын 16,6 хувь гэж байгаа юм. Тэгэхээр энэ дотор чинь тэр нөгөө Азийн хөгжлийн банкнаас авч байгаа нөгөө доллар чинь орчхоод байгаа шүү дээ. Тэгэхээр энийг та нар бас ингэж булхай луйвар хийж байгаа юм шиг ийм юм оруулж хэрэггүй. Тэгээд нэг их том тоо, одоо ингээд л боловсролын салбарт ийм зарцуулалт хийж байна гэххээд багшийнх нь цалин тийм бага байж болохгүй шүү дээ. Зээл, тусламжаа тусад нь ав, наадах чинь тэгээд барилгын л ажил шүү дээ. Багш нарын нийгмийн асуудал дээр ямар ч хамааралгүй. Тэгээд баахан барилга барьчихдаг, багш байхгүй. Тэгээд яаж зохицуулах гэж байгаа юм бэ? Ямар ч тооцоо, судалгаа байхгүй. Тэгээд л нэг юм

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

шинээр гаргадаг, тэгээд л нөгөө юм нь хөрсөн дээрээ буухгүй унадаг, ямар ч тооцоо, судалгаагүй ийм ажил явагдаад байгаа шүү яг шулуун шударга хэлэхэд.../минут дуусав/

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүн асуултаа асууж, хариулт авлаа. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна уу.

Б.Хэрлэн: Би нэг тодорхой зүйл л асууя. Тэгэхээр ер нь бид боловсролын чанар, хүртээмжийн талаар бид их ярьж байгаа. Ялангуяа алслагдсан орон нутагт амьдардаг малчин хүүхдийн боловсрол хэр чанартай байна, тэд нарт ер нь боловсрол эзэмших бололцоо боломж нь хэр хангагдаж байна вэ гэдэг дээр бас их анхаарах хэрэгтэй болоод байгаа. Тэгээд саяхан бид нөгөө хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хэлэлцсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар боловсролын талаар гарсан хууль тогтоомжуудын хэрэгжилт ямар байгаа юм бэ гээд Улсын Их Хурлын Тамгын газраас тайланг нэгтгээд, Байнгын хороогоор хэлэлцүүлж байсан. Энэ тайлан дотор Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь заалтад байдаг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газар батална гэсэн нэг зохицуулалт.

2 дахь нь Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.11 дэх заалтад зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах гэсэн энэ 2 хуулийн зүйл, заалтууд хэрэгжээгүй байна гэсэн ийм дүгнэлт орж ирж байсан. Өөрөөр хэлбэл яг нөгөө хол газар, алслагдсан газар амьдарч суугаа тэр малчин хүүхдүүдэд боловсролыг хүргэхэд өнөөдөр сургуулийн анги танхим гэхээсээ илүүтэйгээр тэр гэрийн сургалтаар, үгүй бол тэр зайн сургалтуудаар энэ сургалт, боловсрол эзэмших боломжийг нь бүрдүүлэх энэ нэг том ажил өнөөдөр танай яамнаас ер нь хэр хэмжээнд хийгдээд байгаа юм бол? Яагаад энэ тайланд энэ талын ажил хийгдээгүй байна гэж тусгагдсан юм бэ? Үр дүн нь гараагүй. Яах вэ тэр юуны цэцэрлэгийнх дээр болохоор цэцэрлэгийг, сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд эзэмшүүлнэ гэсэн. Энэ дээр журмын төсөл бэлтгэгдэж байгаа гэсэн байгаа. Бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлэх гэдэг энэ журмыг энэ тал дээр үр дүн нь байхгүй байна гэсэн ийм юм орж ирж байсан. Тэгэхээр Боловсролын яам энэ тал дээр ер нь яг юу хийж байгаа вэ, энийг ер нь та нар хэр анхаарч байгаа вэ, энийг тодорхой хариулаад өгөхгүй юү?

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Яах аргагүй энэ гэрийн сургалтын журам, зайн сургалтын журам, энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан эхний хагас жилээр гарсан тайланг хэлэлцэж буй үед бол яах аргагүй ийм үр дүн, үзүүлэлттэй нөхцөл байдал бол байсан. Яг өнөөдрийн байдлаар бид ямар ч байсан энэ ондоо багтаагаад энэ 4 дүгээр улирал 1 сарын хугацаа үлдчихсэн байна. Энэ хугацаанд энэ журам бэлэн болохоор эхний draft төслүүд нь гарчихсан, одоо танилцуулагдаад явж байна. Тэгэхээр зайн сургалт өөрөө энэ гэрийн сургалт энэ хоёр бол өөрөө салшгүй уялдаж явах ёстой ийм бас нарийвчилсан зохицуулалт байх ёстой юм байна лээ.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Энэ хүрээнд бид цахим сургуулийг өнгөрсөн сард Засгийн газрын тогтоол гарч албан ёсоор цахим сургуулийг байгуулж байгаа. Тэгэхээр цахим сургууль байгуулагдсанаар энэ сурч боловсрох эрхээр бүрэн хангагдаж чадахгүй нөхцөл байдалтай байгаа гадаадад суралцдаг, бас аливаа нэгэн сургуульд хамрагдаж чадахгүй байгаа гэртээ байдаг зарим нэгэн янз бүрийн хүндэтгэх шалтгаантай энэ суралцагчид цахим сургуулиар, цахим боловсролоор бүрэн хангагдах энэ бололцоог хангахаар энэ бэлэн байдал хангагдсан гэсэн үг. Засгийн газрын тогтоолоор цахим сургууль байгуулагдсан. Одоо энэ сургалтынхаа журмыг батлуулах үлдсэн байна, эхний draft бэлэн байдал хангагдаад ингээд гараад явж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ саяын бидний тулгамдаад байсан нэлээн олон сорилтууд шийдэгдээд явна.

Тэгээд дээр нь бас яг бодитоор алслагдсан, ялангуяа хил орчмын байршил дээр тулгамдсан бага сургуулийн асуудал байдаг. Сумын төв рүү, аймгийн төв рүү эцэг, эхчүүд нь зөөх хүндрэлтэй асуудал. Тэгэхээр бага сургуулийн энэ багийн бага сургууль гэдэг концепцыг нэвтрүүлж, ялангуяа манай аж ахуйн нэгжүүд энэ хөнгөлөлт, ААНОАТ-ынхаа 1 хувийнхаа хөнгөлөлтийн хүрээнд шийдүүлээд ажил хэрэг болгоод нээлтээ хийж байгаа сайн туршлагууд бас байгаа. Тэгэхээр нөгөө талд эрх зүйн зохицуулалтыг нь бид энэ журмаараа тодорхой болгоод зохицуулаад, энэ ондоо багтаагаад батлуулаад, хэрэгжилт бол энэ оны хэрэгжилт хангагдаад явна гэсэн үг.

С.Зулпхар: Хэрлэн гишүүн тодруулж асууна.

Б.Хэрлэн: Тэгэхээр ер нь ерөнхий боловсролын сургуулийн 1, 2 дугаар ангийн сургалтыг, тэр тусмаа сургуулийн өмнөх боловсролын сургалтуудыг гэрээр олгох, эцэг, эхийн оролцоотойгоор гэр сургалтаар энийг энэ боловсролыг хүүхдэд эзэмшүүлэх тухай дээр ер нь танай яамнаас яг тодорхой бодлого, яг юу авч хэрэгжүүлж байгаа юм бол? Энэнээс болоод миний анзаарч байгаагаар хөдөө орон нутгуудад нөгөө эцэг, эх нь хүүхдүүдээ дагаад сумын төв рүү яваад ирэх, эх нь дагаад сумын төв дээр ирээд суурьшчих, тэгээд нөгөө эцэг нь хөдөө малтайгаа ингээд хоцрох, тэгээд эндээс чинь яг энэ боловсролд хамрагдана гэдгээсээ болоод эргээд нөгөө гэр бүлийн бүрэн бүтэн байдал алдагдах явдал бас ингээд гараад байдаг юм байна л даа. Энийг ер нь та нар цаашдаа яг юу гэж бодож байгаа бол, яаж засъя гэж бодож байгаа бол, энэ талаар ямар бодлого авч хэрэгжүүлэх гэж байгаа бол?

С.Зулпхар: Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Энэ ялангуяа бага ангийн сурагчдын хувьд тулгамдаж байгаа яах аргагүй сорилт дагуулсан энэ асуудал байсан. Зүгээр энийг шийдэх хэмжээний хүрээнд бол яг саяын гишүүний тодруулж, санаа зовж асууж байгаа яг энэ журмын зохицуулалт өөрөө маш тодорхой зохицуулалт нь өөрөө тодорхой байж бодлого, хэрэгжилтүүд нэлээн тодорхой хангагдахаар байгаа. Өөрөөр хэлбэл тэр нь гэрийн сургалт явагдаж байгаа зохион байгуулалт нь хангагдахын тулд шаардагдах зардал мөнгө, тэнд заагдах боловсон хүчний бэлэн байдал яаж хангагдах энэ бүхнийг нарийн зохицуулалтыг бүрэн бэлэн байдлыг нэлээн сайн хангах ёстой. Нөгөөтээгүүр энэ журам өөрөө бас нөгөө зайн сургалт, цахим сургалтынхаа журамтай, цахим сургуулийнхаа үйл ажиллагаатай маш нарийн уялдаж тэр боломж бололцоог бүрэн олгосноор зөвхөн гэрээр заах гэдэг сургалт маань өөрөө

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

нэлээн хөнгөвчлөгдөж, нягт уялдаатай ажиллах ёстой. Ер нь хамгийн зөвхөн гэрээр алслагдсан сумд төдийгүй.../минут дуусав/

С.Зулпхар: Хэрлэн гишүүн тодруулж асуух уу? Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууна, микрофоныг өгье.

Ц.Баатархүү: Сайн байцгаана уу? Манай Боловсролын яамныхан тэгээд бас энэ тогтоолын төслийг Дэд хороо өргөн барьж байгаа гэж ойлголоо. Энэ хорвоо дээр байдаг бүх л сайхан үгнүүд байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлж мэргэжилтнүүдийг бэлтгэнэ гэдэг өгүүлбэр бол бүх зүйл дээр л байгаа. Бэлтгэдэггүй. Монгол хэлэнд байгаа бүх сайхан үгийг нийлүүлдэг болсон. Батжаргал даргаа энэ танай яамныхан сууж байгаа биз, ер нь энэ ажил төрөлдөө анхаарч байгаа юм уу, ажлаа өгөхөд бэлэн шинжтэй сууж байна шүү дээ утсаараа оролдоод. Энэ Монголын боловсролын төлөө сэтгэл зүрх байгаа юм уу? Би гайхаж байна. Байнгын хорооныхноос асуулаа энэ Боловсролын яамны хүмүүс мөн үү гэж, мөн гэж байна. Тэгээд нэг ийм хэдэн зүйлийг хэлье гэж бодож байна, асууя гэж бодож байна.

Барилгын яам болохоо боль, албан ёсоор сайддаа хэл, энэ бүх тендер, энэ их барилга барих ажлаас Боловсролын яам татгалзаж байна. Тэр Барилгын яам нь хариуц, худалдан авах ажиллагаа нь хариуц, тендерийн яам болохоо боль. Агуулга өөрчилдөг, багшаа бэлддэг л яам бол, бодлого барьдаг яам бол л доо. Би энэ Батжаргал даргыг мэднэ, их сайн оюутан байсан юм, ингээд их өөрчлөгдчихсөн байна.

Багш бэлтгэх дээр нэг хэдэн зүйлийг энэ байна уу, үгүй юү би асууя. Эхлээд бэлтгэх тогтолцоо байгаа. Бидний үед санаж байгаа бол би улс төр судлаач бөгөөд нийгэм судлалын багшаар төгсөж байсан. Бакалаврынх нь боловсролтой нийцүүлээд сурганых нь хичээлийг, сэтгэл судлалынх нь хичээлийг ороод болдог байсан шүү дээ бэлтгэх тогтолцоо дээр.

2 дугаарт нь энэ гишүүдийн яриад байгаа багшийг тогтвортой ажиллуулах тогтолцоо гэж байгаа шүү дээ. Энэ чинь нөгөө цалин хөлс, нийгмийн баталгааны асуудал.

3 дугаарт нь багш нарыг урих асуудал байгаа шүү дээ. Урьж ажиллуулах, дэлхий даяар байгаа авьяастнуудаа урих, гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг урих ийм 3 зүйл байгаа. Энэ 3 дээрээ дорвитой шинэчлэл орж ирж байгаа юм уу?

Дунд сургууль дээр маш энгийн шүү дээ та нар хичээлийнхээ тоог жоохон нийлүүл, цөөл, химийн лаборатори, физикийн лаборатори гэж тусдаа ийм лаборатори ингээд тавьдгаа боль. Энэ мөнгө л угааж байгаа хэлбэр, ... боловсролын лаборатори гэдэг чиглэл рүүгээ явж байна. Өнөөдөр хөдөлмөрийн хичээл бол 3D принтер болсон шүү дээ. Кодоо бичнэ, эмээ хэвлэнэ, давхар компьютер science-н чадвар нь нэмэгдэж байгаа. Бүх хичээлүүд хоорондоо уялдаатай болчихсон, ийм уламжлалт физик нь өөр, хими нь өөр гэдэг энэ мөнгө төгрөгөө ч гэсэн ингэж тарамдуулж хүрэлцэхгүй ингэж үрдэг, зарцуулдаг байдлыг өөрчилье л дөө. Яагаад та нар энийг хийхгүй байгаа юм бэ? Заавал тусад нь физикийн, химийн, биологийн лаборатори гэж байгуулаад байгаа юм бэ? Байгалийн ухааны лаборатори, туршилтаа нэг дор хийнэ шүү дээ. Хими, биологи 2

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ойролцоо байдаг. Ахлах сургууль дээр энэ ерөөсөө л нэг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэдэг болчихлоо.

С.Зулпхар: Баатархүү гишүүнд цаг нэмж өгье, асуултаа гүйцээе.

Ц.Баатархүү: Ахлах сургууль дээр ерөөсөө л тестийн шалгалтад бэлддэг, тест цээжилж байна 12 дугаар ангийн хүүхдүүд. Амьдралд бэлтгэх, мэргэжилд бэлтгэх, төрөлжүүлэх энэ ажил явахгүй байна шүү дээ. Яаж элсэлтийн шалгалтад тэнцэх вэ гэдэг ийм юм руу явж байна.

Дээд боловсрол дээр их сургуулиа та нар энэ тогтоолын төсөл дээр энэ бас Удирдлагын академид ажиллаж байсан туршлагатай багш нар байж байна шүү дээ, бас л ерөнхий байна. Судалгааны их сургууль, мэргэжлийн их сургууль, коллеж гээд түвшнүүдэд нь хуваагаад өг. Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургуулиа судалгааны их сургууль болгоё, 99 хувь нь оюутны төлбөрөөр амьдардаг ийм дээд боловсрол байж болохгүй. Судалгаа, шинжилгээгээр амьдардаг болъё, хөгждөг болъё, компаниудын захиалгаар ажил гүйцэтгэдэг болъё. Гаднаас багш нараа урья.

С.Зулпхар: Асуултад хариулъя. Дараа нь Баатархүү гишүүн тодруулж асууна. Батжаргал дарга хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр гишүүний асуусанчлан яг энэ санаа зовж байгаа, бидэнд зөвлөмж өгч байгаа яг энэ асуудлыг Боловсролын багц хуулиар түүнийг хэрэгжүүлэх энэ ажлын хүрээнд ялангуяа энэ хөтөлбөрийн шинэчлэл дээр хичээлүүдийн тоог, ялангуяа тоо гэхээс илүүтэйгээр чанар, хүүхдүүдийг, сурагчдыг ур чадварт эзэмшүүлэх рүү чиглэсэн хичээлүүдийг бас энэ интеграцчилж, зарим нэг нэгдсэн байдлаар саяын байгалийн ухаан гэдэгчлэн, ялангуяа сүүлийн үеийн хамгийн нэн тулгамдаж шинэчлэл шаардаж байгаа мэдээлэл технологийн салбар, тэр тусмаа хиймэл оюун, багш нарын ур чадварыг бэлтгэх эдгээр шинэчлэлийн асуудал бол хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бүрэн хийгдээд, үе шаттайгаар энэ ажлууд маань үр дүнгээ өгөөд эхэлнэ гэж ингэж харж байгаа.

Дээд боловсролын тухайд бас яг гишүүний хэлсэнчлэн мэргэжлийн их сургууль, судалгааны их сургууль, сургалтын их сургууль гэсэн энэ Дээд боловсролын тухай хуулийн шинэчлэлээр оруулж өгсөн энэ хэрэгжилт хангагдаад, Засгийн газраар энэ техникийн зохицуулалт гэж энэ зохицуулах, энэ ангилал тогтоох энэ аргачлалаа батлуулаад, энэний хүрээнд үе шаттай аргачлалынхаа дагуу ангиллыг нь мэргэжлийн их сургууль нь ямар нь байх юм, ямар шаардлага хангах ёстой юм тэрний дагуу хэрэгжилт бол хангагдаад явж байгаа.

Яах аргагүй таны хэлсэнтэй санал нэг байгаа. Ялангуяа судалгааны их сургууль, тэр тусмаа мэдлэгт суурилсан инновацлаг, инновацаа эдийн засгийн эргэлтэд оруулдаг энэ чиглэл рүү их сургуулиуд маань ялангуяа хамгийн анхны судалгааны их сургууль байгуулахаас эхлээд явах ёстой. Тэрний тулд Судалгааны их сургуулийн тухай хууль бэлэн болох ёстой. Тэгэхээр Судалгааны их сургуулийн тухай хуулийн боловсруулах бэлэн байдал, ажлууд бол хийгдэж байгаа. Гаднын дэмжлэг, туслалцаа, туршлагыг ч гэсэн авахаар Азийн хөгжлийн банк энэ тал дээр онцгойлон анхаарч, дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж ингэж хамтарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

С.Зулпхар: Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Тэгээд чиглэл зөв байвал тэгээд үр дүнд хүрэх байх. Ер нь явц бол удаан байгаа шүү, би сэтгэл дундуур байгаа боловсролын салбарт. Гишүүд ч сэтгэл дундуур байгаа, эцэг, эхчүүд ч сэтгэл дундуур байгаа. Бид ингээд их зөв юм яриад байдаг болчихлоо энэ ордон дотор. Хийдэг, хэрэгжүүлдэг хүн байхгүй. Би яамны ажлыг мэднэ, энэ газрын дарга нар чинь хуулиа бичихгүй. Тэгээд нэг тендер зарлаж, хуулийн баг авна гээд л хүлээж байгаа. Сангийн яам нь мөнгийг нь өгөхгүй л байж байгаа, зовлон, жаргалыг чинь би ойлгож байна. Тэгээд нэг Судалгааны их сургуулийн хууль бичнэ гээд нэг хуулийн баг хүлээсэн, ингээд ажил чинь явахгүй шүү дээ Батжаргал даргаа. Өөрсдөө шөнө суу л даа, ажил хий л дээ. Үнэхээр энэ гүйцэтгэх түвшинд энэ боловсролын салбар энэ сайн ажиллах хэрэгтэй байна. Тэгээд би бол дэмжээд хамтраад ажиллахад болно. Тэгээд энгийн юмнаасаа эхэлье л дээ. Их сургуулийнхаа гүйцэтгэлийн үнэлгээг төгсөгчдийнх нь хэдэн хувь нь ажлын байранд.../минут дуусав/

С.Зулпхар: Баатархүү гишүүнд цаг нэмж өгье.

Ц.Баатархүү: Тэрнээс эхэлье. Тэгээд багш нарыг уриад 25, 25 тэрбум төгрөг энэ жил ШУТИС, МУИС дээр гаднын профессоруудыг авчиръя гэхээр та нар дэмжихгүй юм. Тэд чинь энд ажлын байр, цалин нэмээд, орон байраа шаарддаг юм байна лээ шүү дээ. Казакстан тэгж дээд боловсролоо Азийн хэмжээнд авчирлаа. Бээжингийн их сургууль, Чинхуагийн их сургуулийн жишгийг хар л даа. Ядаж Монгол Улсын Их сургуулиа хэдүүлээ өөд нь татъя, Азийн хэмжээнд аваачихъя л даа. Ямар сонин ийм сэтгэлгүй, зүтгэлгүй, санаа зовнилгүй байдаг юм бэ гэж би гайхаад байгаа.

Тэгээд энэ хиймэл оюунаар эхний ээлжид зүгээр гэрийн даалгаврыг шалгадаг л болгочихъё. Багш нарын чинь ачаалал буурна. Их олон юм яриад хэдүүлээ амжихгүй, хиймэл оюуны хөөсрөл явж байна, 5 жилийн дараа хэрэглээнд маш сайн нэвтэрнэ. Эхний ээлжид энэ гэрийн даалгавар энэ их бичиг цаасыг нь багасгаад өгчихье л дөө. Тэгээд энэ дээрээ ингээд.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга нэмэлт асуултад хариулъя.

Х.Батжаргал: Гишүүдийн асуултад нэмж тодруулъя. Тэгэхээр ер нь манай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр хичээл сургалтын хөтөлбөрийнхөө 20 хувийг, 20 хүртэлх хувийг англи хэл дээр явуулж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх энэхүү заалтын хүрээнд гаднаас багш урьж оролцуулах энэ ажил хэрэг бол бас мэдээж төсвөөс хамаарах ажил. Тэгээд энэ батлагдсан төсвийн хүрээнд Боловсролыг дэмжих жилийнхээ хүрээнд энийг эрчимжүүлж явуулах боломжтой гэж харж байгаа.

Нөгөөтээгүүр сургалтын энэ чанарыг ахиулах үүднээс дээд боловсролын салбарын хувьд тухайлбал эрэмбэ чансааг тогтоох энэ ажлыг бол нэлээн чанаржуулж, ерөнхий боловсролын сургууль, СӨБ дээр гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг, тэгвэл тэрний дүйцэх хэмжээнд эрэмбэ чансаа тогтоох энэ ажлыг нэлээн эрчимтэйгээр, хөндлөнгийн хараат бус байдлаар, энэ хүрээндээ бас яг ямар.../минут дуусав/

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир асуулт асууна.

Д.Бум-Очир: Баярлалаа. Гишүүд хэлж байна. Сая Баатархүү гишүүн бас хэлж байна. Бид нэг олон улсын түвшинд л хүргэмээр байна л даа. Жишээ нь Монголын энэ ерөнхий боловсролын төгсөж байгаа гэрчилгээ сертификатыг олон улсад ер нь яаж хүлээн зөвшөөрдөг юм бэ? Ер нь олон улсад яадаг юм бэ, дэлхий дээр? Бид чинь нөгөө Америкийн АСТ энэ тэр гэдэг юм л яриад байх юм. Энэ сертификатуудыг үнэлдэг байгууллагуудаар энэ боловсролын сертификатуудаа яаж үнэлүүлэх юм бэ, энэ ажил яаж хийгдэж байгаа юм бэ? Жишээ нь Монголд би өмнө нь бас асууж байсан санагдаж байх юм. Монголд бакалаврын, магистрын, докторын гэрчилгээ авсан бол миний мэдэхээр жишээ нь Хятад бол зарим сургуулиуд нь, байгууллагууд нь зөвшөөрнө, зөвшөөрөхгүй гэдэг зүйл яригдаж байна шүү дээ.

Энийг би яагаад ярьж байна вэ гэхээр манай МУИС дээр Өвөр Монголоос энэ тэр Хятадаас оюутнууд ирдэг. Тэгээд төгсөөд очихоор манай гэрчилгээг тэнд магистрын, докторын гэж зөвшөөрдөггүй. Энэ байдлаа бид шат дараатайгаар нэг халах хэрэгтэй болоод байна л даа. Тэгэхээр яаж энэ шат шатны боловсролын гэрчилгээгээ олон улсад хүлээн зөвшөөрдөг болгох вэ 1 дүгээр зүйл?

Яг үүнтэй холбоотой дараагийн нэг зүйл энэ тогтоол дээр би сая харж л байна л даа. Би бас урьд нь хэлж байсан. Дэлхийн олон улсын их сургуулиудыг үнэлдэг үнэлгээний тэр ранк дээр одоо боломжтой байгаа сургуулиудаа оруулаад, тэгээд тэр эрэмбэлэгдэж байгаа эрэмбийг нь ахиулах гээд бүүр тусгавал яадаг юм бэ? Тэгээд тэрэн дээр нь тэр шаардлагатай бол мөнгө санхүүжилт юу хэрэгтэй байгаа юм, тэрийг нь төрөөс дэмжээд, олгоод явах энэ чиглэлийн заалтуудыг оруулчихвал яасан юм бэ? Би бас асууж байсан. Та Анагаах 1200-д гэж байсан санагдаад байна тийм ээ. Би тэр мэдээлэл нь надад ирээгүй байна. МУИС миний мэдэхээр 1500 гээд байж байгаа. Энэ өнгөрсөн 30 жилийн туршид л ийм байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг богинохон хугацаанд тэр Казакстаны жишээ энэ тэрийг сая яриад гээд байна. Жишээ нь тэр Кембриджийн сертификат үнэлдэг үнэлгээний газар байгаа шүү дээ. Тэр үнэлгээний газруудаар энэ тэр үнэлүүлэх байдаг ч юм уу, одоо яадаг юм шат дараатай арга хэмжээнүүд аваад явбал болохгүй юу? Одоо ер нь энэ чиглэлд ямар ажлууд хийгдэж байгаа вэ?

С.Зулпхар: Асуултад хариулъя, 2 дугаар микрофон.

П.Оюунаа: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал Оюунаа байна. Дээд боловсролын боловсролын баримт бичгийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхтэй холбоотой өнгөрсөн жил олон улсын нөгөө юу дээд боловсролын зэрэг цолыг хүлээн зөвшөөрүүлэх конвенцыг Улсын Их Хурлаар батлуулсан. Энэ конвенцын хүрээнд конвенцод нэгдсэн одоогоор 29, 33 орон байгаа сүүлийн мэдээгээр. Тэгэхээр эдгээр орнуудад боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрүүлэх ажлыг эхэлсэн байгаа.

Гэхдээ энэ бол үе шаттай явагдана. 1 дүгээрт нь яадаг гэхээр тэдгээр улсуудад мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй болдог. Мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг бид мөн өнгөрсөн жилд Засгийн газраар батлуулсан. Одоо Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтдаа шаталсан бүтцэд мэргэшлүүдийг яаж бүртгэж, баталгаажуулах вэ гэдэгтэй холбоотой журмыг батлуулах шаардлагатай байгаа. Энэ журам хэрвээ

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

батлагдчихвал бид дээд боловсролын мэргэжлүүдээ бүртгээд, баталгаажуулаад, конвенцод нэгдсэн улсуудаар энэ шаталсан бүтцээ хүлээн зөвшөөрүүлэх ажлыг эхэлнэ. Энэ бол үе шаттай хийгдэж байгаа. Ингэсэн тохиолдолд тухайн мэргэжлийн үндэсний шаталсан бүтэц дээр байршсан мэргэжлийн сертификат, дипломуудыг бид олон улсад хүлээн зөвшөөрүүлэх боломжтой болж байгаа дээдийн хувьд.

Мэргэжлийн боловсролын хувьд бид 82 оронд хүлээн зөвшөөрөгдсөн ийм IT-ийн мэргэжлийн үнэмлэх бүхий сургалтыг эхлүүлсэн, анхны төгсөлт ирэх жил болно. Тэгэхээр энэ байдлаар бид үе шаттай бас олон улсад энэ боловсролын баримт бичгээ хүлээн зөвшөөрүүлэх ажлуудыг эхэлж байгаа.

С.Зулпхар: Бум-Очир гишүүн тодруулж асуух уу? Би хуралдаан даргалагчийн хувиар, бас гишүүний хувиар 2 асуулт их тодорхой асуулт асууя. Сая манай гишүүд их тодорхой юм асуугаад байна, бас прагматик асуудалд хандаж байгаа учраас. Тухайлбал Баатархүү гишүүн их, дээд сургуулиудын сургуульд нь гаднын жишээ нь ижил төстэй мэргэжлээр хүлээн зөвшөөрөгдсөн багш нарыг урьж ажиллуулах энэ саналыг та бүхэн яаж авч үзэж байна вэ гэсэн асуулт асууж байна. Өнгөрсөн бидний уулзалт дээр ч гэсэн бас яригдаж байсан санал л даа. Энэнтэй холбоотойгоор хамгийн гол нь тэр багш нарыг урьж авчрахад шаардлагатай зардал мөнгө, бусад нөгөө орон байраар хангах асуудалтай уялдсан энэ чиглэлээр та бүхний хангаж байгаа бэлтгэл байна уу гэсэн нэг ийм асуулт байгаа юм. Их тодорхой нэгэнтэй ажил учраас тодорхой бэлтгэл хангагдаагүй бол би бас ахиад л сая Баатархүү гишүүний хэлдэг шиг цаасан дээр үлдчихвэл энэ бол ажил болохгүй. Энэ их тодорхой зүйл.

2 дахь нь энэ дээд боловсрол дээр олон улсын магадлан итгэмжлэлд орох тухай чухал нэг тийм зохицуулалт байдаг, бас ийм санаачилга байдаг. Зарим сургуулиудын зарим хөтөлбөрүүд нь ороод, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Тэрийгээ дагаад тэр диплом өөрөө хүлээн зөвшөөрөгдөж байгаа ийм хэлбэрүүд байна л даа. Ойрмогхон жишээ нь зарим хөтөлбөрүүд орж эхэлж байна. Тэгэхлээр энэ дээр та бүхэн ямар жишээ нь бодлого, чиглэл барьж байна гэдгийг би зориуд асууя? Дээд боловсролын асуудал хариуцсан газрын дарга маань өөрөө байгаа учраас өмнөх хурлууд дээр би бас энэ дээр байсан эсэхийг сайн мэдэхгүй байгаад байна, тодорхой хариулаад өгөөч гэж байгаа юм. Батжаргал дарга ч гэсэн нэмэлтээр тайлбар хийж болох байх. Би энэ дээр дээд боловсрол хариуцсан манай дарга ирсэн байна шүү дээ тийм ээ. Нарангэрэл даргыг хариулаач гэж урьж байна. Нарангэрэл дарга 2 дугаар микрофон дээр оччих уу? 6 дээр очсон ч болно. Батжаргал дарга хариулъя гэж байна. Батжаргал даргыг сонсьё, 1 дүгээр микрофон.

Х.Батжаргал: Би гишүүний эхний асуултад хариулж байя. Энэ яг гаднын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамтарсан судалгаа хийх, судалгааны үр дүнгээ хамтарч хуваалцах гээд энэ олон ажлуудыг хийгдэж байгаа сайн туршлага өнгөрсөн 10 жилд хийгдэж байсан. Юу вэ гэхээр зэрэг мянган инженерийг бэлтгэх Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа энэ төсөл одоо хэрэгжилт бол 95 хувьтай. Энэний хүрээнд зөвхөн мастер, докторт оюутнуудыг Япон улсад мэргэжил эзэмшүүлэхээс гадна, Япон улсын өндөр нарийн мэргэжлийн эрдэмтэн, профессорууд Хөдөө аж ахуйн сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол Улсын Их сургуулиуд дээр хамтарсан судалгааны баг гарч

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ажиллаж, тодорхой хугацаанд 45 хоног хүртэлх хугацаанд нарийн мэргэжлийн профессор, эрдэмтэд ажиллаж байгаа.

Энэ төсөл өөрөө амжилттай сайн явагдсан суурийг нь, бас сайн туршлагыг нь нэвтрүүлээд энэ 2 дахь үе шатыг дараагийн 10 жилд хэрэгжүүлэхээр одоо бэлтгэл ажлууд хийгдээд ингээд явж байгаа. Тэгэхээр зөвхөн инженерүүдийг гадаадад бэлтгэнэ гэхгүйгээр гадаадаас нарийн мэргэжлийн хамтарсан судалгааны баг эдгээр сургуулиудад бас ажилласан сайн ийм туршлага байна. Энийгээ дараагийн шатад дахиж гаргаж ажиллахаар байгаа.

С.Зулпхар: Баярлалаа, их тодорхой хариулт өгч байна. Нэг зүйлийг бас тодруулчихъя. Сая Баатархүү гишүүн их тийм чухал юм асууж байна шүү дээ. Бид угаасаа энэ тогтоолын төсөлд оруулчихсан байж байгаа ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хиймэл оюун ухааны жишээ нь агуулгыг оруулъя гээд. Яах вэ энэ бол сурагчид руу чиглэсэн нэг үйл ажиллагаа байх. Гэтэл энэ хиймэл оюун ухааны тэр боломжуудыг хичээлийн даалгавар шалгахтай холбоотой энэ үйл ажиллагаанд ч юм уу ашиглаж болох чиглэлээр та бүхэн ямар санал санаачилга, эсвэл ямар зохицуулалт хийж байгаа юм бэ гэдэг зүйл асууж байна. Тэгэхлээр энэнтэй уялдсан байдлаар ер нь багш нарыгаа хиймэл оюун ухааны чадавхыг нь бэхжүүлэх чиглэлээр, сайжруулах чиглэлээр ажил хийгдэх үү? Энэ дээр та бүхний бодож төлөвлөж байгаа зүйл байна уу? Батжаргал дарга 1 дүгээр микрофон.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж тодруулъя. Тэгэхээр яах аргагүй маш цаг үеийн шинжтэй маш чухал асуудал. Хиймэл оюуны чиглэлээр ер нь шинээр хийгдэх гэлтгүйгээр өнгөрсөн хугацаанд боловсролын салбарын бүхий л дата өгөгдлийг дижитал цахим болгож, бэлтгэл ажлуудыг хангагдаж явж байгаа. Тэгэхээр энэ боломж дээрээ үндэслээд их өгөгдөлд суурилсан хиймэл оюуны хэрэгжүүлэх хамгийн гол асуудал бол дата өгөгдөл байдаг. Тэгэхээр боловсролын салбарын хувьд салбарынхаа хэмжээний их өгөгдлийг цахим дата hub болгож, бэлэн байдлыг хангасан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ дэлхийн тэргүүлэгч энэ компани болох Google компанийн гаргасан Google Gemini энэ моделийг ашиглаж, багш нараа бэлтгэж байна хиймэл оюунд. Хиймэл оюуныг цааш нь сургах сургагч багшийг 4 мянган сургагч багшийг Google компани бэлдэж, санхүүжүүлж, бэлтгэл ажлууд хийгдэж байна. Мөн энэ туршлага дээр.../минут дуусав/

С.Зулпхар: Батжаргал дарга нэмж хариулъя.

Х.Батжаргал: Багшийн туслах гэсэн концепцыг нэвтрүүлж ажиллахаар байгаа. Өөрөөр хэлбэл багшийн цагийг их авдаг нэмэлт ачаалал, хөтөлбөр, хичээлийн бэлтгэл ажил хангах энэ томоохон цаг эзэлдэг энэ ажлыг хиймэл оюунаар явахад бол одоо бүрэн бэлтгэл хангагдаад явж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ хичээлийн сургалтын энэ хөтөлбөрүүдийг сурах бичгүүдийг бүрэн цахимжуулж, гаднын платформуудыг нэвтрүүлээд, гаднын бэлэн платформ өөрөө бас хиймэл оюун дээр түшиглэсэн, суурилсан шалгах, шалгуулах, бэлтгэх, хичээл бэлтгэх гээд бүрэн, иж бүрэн үе шатлалтай ажлууд нь бэлэн байгаа учраас тэрийг өнгөрсөн хугацаанд ашиглаад, туршаад ирсэн. Харин илүү өргөжүүлэх, үр дүнг нь нэмэгдүүлэх чиглэл дээр багш нараа илүү сайн бэлтгэх, мэргэжлийн ажлын байран дээрээ мэргэшсэн байдлыг нь хангах чиглэл дээр хиймэл оюуны бэлтгэл энэ ажлуудыг агуулгын хүрээнд улам эрчимжүүлж ажиллана гэж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

С.Зулпхар: Баярлалаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлж, санал хэлж болно. Гишүүд нэрсээ нэрсээ өгнө үү? Гишүүд, асуулт асуух гишүүн байхгүй, биш ээ санал хэлэх гишүүн байхгүй. Саналыг тасалъя. Би бас гишүүдийн асуусан асуулт, саналтай холбогдуулаад дүгнэж хэлье гэж бодож байна. Тогтоолын төслийг батлахын өмнө.

Бид энэ тогтоолын төслийг 2026 оныг Боловсролын жил болгож байгаатай уялдуулаад Дэд хорооны гишүүд маань санаачилсан. Дэд хорооны гишүүд боловсрол өөрөө бол том тогтолцоо, түүн дотроо тодорхой холбогдох дэд тогтолцоонуудтай. Бүхэлд нь авч үзэж байж бид Боловсролын жилд тодорхой үр дүн гарах ёстой гэж ойлгож байгаа 1 дүгээрт.

2 дугаарт өнгөрсөн хугацаанд хийгдсэн тодорхой сайн ажлууд байна, сайн туршлагууд ч байна. Тэрнийг цааш нь бид үргэлжлүүлэх учиртай учраас энэтэй уялдсан тодорхой саналуудыг бас энд тусгаж байгаа, тодорхой чиглэлүүдийг. Нөгөөтээгүүр Монгол Улсын Засгийн газраас өөрийнхөө үйл ажиллагааны чиглэл дотор зорилт болгочихсон хэрэгжүүлээд явж байгаа ажил байгаа юм. Тэгээд тэр хэрэгжүүлээд явж байгаа ажлуудыг бид заримыг нь сайн туршлага, зарим нь гарцаа байхгүй богино хугацаанд хийх ёстой ажил гэж үзэж байгаа учраас энэ тогтоолын төсөлд тусгасан гэдгийг хэлье.

Сая гишүүдийн гаргасан санал бол зарим нь тодорхой гарсан саналтай уялдуулаад нэмэлтээр өөрчлөх байдлаар орж байгаа саналууд байна. Зарим саналууд бол шинэ санал байна. Шинэ санал гэдэг нь сая ерөнхий боловсролын сургалттай холбоотой, дээд боловсролтой холбоотой, мэргэжлийн боловсрол дахь хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан гэх мэтчилэн ийм саналууд гарч байна. Энийг бас тусгах зайлшгүй шаардлагатай гэж ойлгож байгаа юм. Энд бидний бэлэн болгосон тогтоолын төсөл өөрөө 4 бүлэг, 23 жишээ нь зүйл юм байгаа юм. Тэгэхлээр энийг аль болох л бид тодорхой, гэхдээ мэдээж хэрэг бидний сүүлийн үед баримталж байгаа тодорхой зарчим байгаа шүү дээ. Аливаа жишээ нь гаргаж байгаа зорилт бол өөрөө 1 дүгээрт үндэслэлтэй, 2 дугаарт энэ бол хэмжиж болдог, 3 дугаарт үр дүн нь бас тодорхой. Тэгээд энэнээс гараад жишээ нь үйл ажиллагаа нь бас хийгдэх ийм хэлбэртэй, хэрэгжих хэлбэртэй байх ёстой гэдэг үүднээс оруулсан зүйл байгаа юм.

Зарим тогтоолын зүйл, тогтоолын төсөлд оруулсан зарим зорилтууд бол ер нь дунд болон урт хугацаанд боловсролын том тогтолцоо болон дэд тогтолцоонд өөрийнхөө үр дүн, үр нөлөөг үзүүлэх ийм хэлбэртэй байгаа гэдгийг зориуд тэмдэглэх ёстой. Шинээр хэрэгжүүлэх, тухайлбал англи хэлний сургалтын асуудал бол маргааш шууд үр дүн нь нэг их тийм айхтар мэдэгдэхгүй ч гэсэн 2-оос 3 жилийн дараа тодорхой үр дүнгүүд авчирдаг ийм өөрөө тогтолцоо. Магадгүй 5, 6 жилийн дараа бол ахиад үр дүн гардаг ийм үйл ажиллагаа учраас энэтэй холбоотой зүйлийг тусгасан байгаа шүү гэдгийг хэлье.

Мэргэжлийн боловсролд бол их онцгойлон ач холбогдол өгч байгаа. Жил болгон мэргэжлийн боловсрол суралцагчдын тоог бол нэмж байгаа. Тэгэхлээр энэ нэмэгдэж байгаатай уялдуулаад хүссэн ч, эс хүссэн ч бид хөдөлмөрийн зах зээлтэйгээ уялдсан ийм сургалтын хөтөлбөрийн агуулга болон зохион байгуулалтыг чухалчилж байгаа. Энд төр, хувийн хэвшлийн түншлэлийг чухалчилж байгаа гэдгийг хэлье.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Төсөвтэй уялдсан байдлаар бидний оруулсан бас санал бий. Тэр нь юу гэхлээр зэрэг өнгөрсөн жилүүдэд боловсролын салбарт хэрэгжсэн санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг санхүүгийн түрээс хэлбэрээр жишээ нь ашиглаад, боловсролын салбарт тулгамдаж байгаа зарим нэг хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэж байгаа нь сайн туршлага байгаа юм. Тэгэхлээр энийг бид чухалчилж байгаа. Тэгж байж жишээ нь сургуулиудыг техник хэрэгслээр хангах, цахим шилжилтийг хийхэд шаардлагатай зарим зорилтуудыг хангах боломжтой юм гэдэг үүднээс энэ асуудлыг тусгасан.

Цалин, мөнгөний бодлого бол угаасаа жишээ нь Засгийн газрын чухал зорилт болчихлоо, эхний шийдвэрүүд гарсан. Бид энэ шийдвэрүүдийг зохих түвшинд бүгд дэмжиж гаргасан шийдвэр байгаа. Цаашдаа энийг яг жишээ нь тогтвортой аваад явах чиглэлээр энэ тогтоолын төсөлд тусаж байгаа шүү гэдгийг энд та бүхэнд онцгойлон тэмдэглэж байна.

Ингээд мэдээж хэрэг бид тогтоолын төсөлтэй холбоотой санал хураана. Тэгэхдээ сая гишүүдийн хэлсэн саналуудыг энэ одоо боловсруулж байгаа тогтоолын төсөлд нэмэлтээр, өөрчлөлт хэлбэрээр оруулах ийм чиглэлийг барина. Тэгээд бид одоо та бүхэнд санал хураалгана. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад бид дараах байдлаар саналыг хураах нь. Гишүүдээс гаргасан саналыг тогтоолд нэмж тусган “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалтад бэлдье. Гишүүд, Бум-Очир гишүүн ороогүй байх шиг байна, Рэгдэл гишүүн бас ороогүй байна уу, орчихлоо. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя.

Дэд хорооны хуралдаанд оролцож буй 9 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 62.5 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд оролцсон гишүүддээ бүгдэд нь талархсанаа илэрхийлье.

16.07 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ